



ЭРҮҮЛ МЭНД, СПОРТЫН ЯАМ
СЭТГЭЦИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ҮНДЭСНИЙ
ТӨВИЙН ЕРӨНХИЙ ЗАХИРЛЫН
ТУШААЛ

2016 оны 04 сарын 08 өдөр

Дугаар 5/46

Улаанбаатар хот

Эмнэлгийн тусламж үйлчилгээнд тавих хяналтыг
сайжруулах тухай

Монгол Улсын Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.1, 16.5.4, Сэтгэцийн эрүүл мэндийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.3.1, Эрүүл мэнд, спортын сайдын 2015 оны 449 дүгээр тушаал, Удирдлагын зөвлөлийн 2016 оны 04 дүгээр сарын 07-ны өдрийн хурлын шийдвэрийг үндэслэн ТУШААХ НЬ:

1. Нийгэм, эдийн засгийн хүндрэл бодитоор бий болж сэтгэцийн эмгэгтэй эмчлүүлэгчдийн тоо нэмэгдэж клиникүүдийн орны ачаалал эрс ихсэж, нийгэмд болон өөртөө аюултай үйлдэл ихээр хийж байгааг онцгойлон авч хэлэлцэн эмнэлгийн тусламж үйлчилгээ, ажилтнуудын ажлын хариуцлагыг сайжруулах зорилгоор жижүүрийн эмчийн өрөөнд камерын хяналтын системийг байрлуулахыг Нийгмийн эрүүл мэнд, эрдэм шинжилгээ, сургалт, гадаад харилцаа, статистик, тандалт судалгаа эрхэлсэн дэд захирал /В.Баярмаа/-д үүрэг болгосугай.

2. Шөнийн ээлжинд ажиллаж байгаа жижүүрийн эмч, сувилагч, туслах сувилагч, бусад ажилтнуудын ажлын хариуцлагыг сайжруулж клиникүүд, тасгуудын ажилтнуудтай дотуур холбооны утас эсвэл бусад хэлбэрээр холбоо барьж утсаар рапорт авч байх боломжийг судлан шийдвэрлэж, хэрэгжүүлж, жижүүрийн эмчийн үүрэгт тусгахыг Эмчилгээ эрхэлсэн дэд захирал /О.Ганчулуун/, Нийгмийн эрүүл мэнд, эрдэм шинжилгээ, сургалт, гадаад харилцаа, статистик, тандалт судалгаа эрхэлсэн дэд захирал /В.Баярмаа/ нарт үүрэг болгосугай.

3. Энэ тушаалын хэрэгжилтийг 2016 оны 04 дүгээр сарын 14-ний Удирдлагын зөвлөлийн хуралд танилцуулахыг Эмчилгээ эрхэлсэн дэд захирал /О.Ганчулуун/, Нийгмийн эрүүл мэнд, эрдэм шинжилгээ, сургалт, гадаад харилцаа, статистик, тандалт судалгаа эрхэлсэн дэд захирал /В.Баярмаа/ нарт үүрэг болгосугай.



ЕРӨНХИЙ ЗАХИРАЛ

Л НАСАНЦЭНГЭЛ

020258